



МОНГОЛ УЛС  
БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГА

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас: (976) 7042-2483, Факс: (976) 7042-3603  
E-mail: info@bo.gov.mn  
<http://www.bayan-olgi.gov.mn/>

2023 11.28 № 201/1138  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН ЯАМАНД

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, тус аймгийн Засаг даргын хооронд байгуулсан 2023 онд хамтран ажиллах гэрээний биелэлт болон 2024 онд хамтран ажиллах гэрээнд тусгах саналыг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт хуудастай.

ЗАСАГ ДАРГА



А.КАМЕЛИЯТ

0105232001

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ  
2023 ОНД БАЙГУУЛСАН ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ**

2023.11.27

Өлгий сум

№	№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Санхүүжил тийн эх үүсвэр/сая төгрөгөөр/	Хүрэх үр дүн	Суурь түвшин	Шалгуур үзүүлэлт /тоо хэмжээ/	Хүрсэн түвшин	Хувь
<b>1. Байгаль орчны холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах</b>								
1	1	Байгаль орчны эсрэг гэмт хэрэг зөрчлийг бууруулах зорилгоор нэгдсэн хяналт шалгалт зохион байгуулах	2.0	12 удаагийн хяналт шалгалтыг суманд зохион байгуулж, байгаль орчны эсрэг гэмт хэргийн зөрчил 5 %-иар буурсан байна.	2022 онд 8 удаагийн хяналт шалгалт зохион байгуулсан	12 удаагийн хяналт шалгалтад  12 сумыг хамруулна.	Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Цагдаагийн газар, сумдын Засаг даргын Тамгын газартай хамтарч байгаль орчны хяналт шалгалтыг зохион байгуулан ажилласан. Нэгдсэн хяналт шалгалтаар хууль бусаар мод бэлтгэсэн, ан амьтан агнасан, байгалийн ургамал түүж бэлтгэсэн, хог хаягдал ил задгай хаясан зөрчилд нийт 2 аж ахуйн нэгж, 6 иргэнд 1,710,000 төгрөгийн торгууль, 120.000 төгрөгийн нөхөн төлбөр тавьж 100% барагдуулж ажилласан ба хяналт шалгалтын явцад хураагдсан 3 ширхэг загасны тор, 12 ширхэг монгол хадран загас, 397 кг барагшууныг Өлгий, Дэлүүн сумдын Засаг даргын дэргэдэх орон тооны бус зөвлөлд шилжүүлэн шийдвэр гаргуулан ажиллав. Мөн хууль бусаар 1 тооны зэгсний гахай агнасан, зөвшөөрөлгүй 162 ширхэг эсгий гэрийн мод бэлтгэсэн, хууль бусаар түгээмэл тархацтай ашигт малтмал болох хайрга олборлож тээвэрлэсэн 2 зөрчлийг илрүүлж, зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж харьяаллын дагуу шалган шийдвэрлүүлэхээр Цагдаагийн газарт хүргүүлж ажилласан ба Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 01/05 дугаар “Ан агнах, барих, худалдах, худалдан авах, тээвэрлэх байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн	100

						<p>дагуу 2023 оны 08 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн өдөр бүр Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, ЗӨСТ, Өлгий сумын ЗДТГ-ын холбогдох албан хаагч нартай хамтарч аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын байгаль орчны хяналтын улсын /ахлах/ байцаагчид, байгаль хамгаалагчид нийт 45 хоног эргүүлийн хяналт шалгалт хийж ажилласан. Хяналт шалгалтын явцад хууль бусаар 97 ширхэг алтай тарвага агнасан зөрчлийг илрүүлж одоогийн байдлаар 74 ширхэг алтайн тарвага агнасан 13 иргэнд 3,900,000 төгрөгийн торгуулийн шийтгэл, 68,080,000 төгрөгийн нөхөн төлбөр ногдуулж, хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж ажилласан ба зөрчил үйлдэхэд ашигласан 13 ширхэг галт зэвсгийг хураан авч, улсын орлого болгуулахаар аймгийн Цагдаагийн газарт хүргүүлэв. Мөн 3 ширхэг алтайн тарвага агнасан 2 зөрчилд зөрчлийн хэрэг нээж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж байна. Нийт шалгалтаар илрүүлсэн 97 ширхэг алтайн тарвагыг шинжлүүлэхээр аймгийн Зооноз өвчин судлалын төвд хүлээлгэн өгөв. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй ШТС, нам даралтын зуух ашиглаж байгаа үйлчилгээний газрууд, жуулчны бааз, амралтын газар, мал төхөөрөх үйлдвэр, авто засвар авто угаалга, уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй компаниудад болон хууль бусаар ан агнах, загас барих, түгээмэл тархацтай ашигт малтмал орборлох зэрэг зөрчилд давхардсан тоогоор нийт 120 удаа хяналт шалгалт хийсэн.</p>	
--	--	--	--	--	--	--	--

2	2	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын албан хаагчдын нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх	15.0	-Албан хаагчдыг 2 удаагийн сургалтад хамруулсан байна. -5 байгаль хамгаалагчийг тээврийн хэрэгслээр хангасан байна. 44 хүнийг 1 удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулсан байна.	2022 онд 4 байгаль хамгаалагчийг мотоциклээр хангасан.	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 5 байгаль хамгаалагчийг мотоциклээр хангасан байна.	Удирдлагын академийн богино хугацааны багц сургалтад 29 албан хаагч хамрагдаж, үнэмлэх авсан. Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас зохион байгуулсан танхимын сургалтад 5 албан хаагч, цахим сургалтад 33 албан хаагч Мөн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Зөрчилийн тухай хуулиуд болон байгалийн нөөц ашигласны төлбөрийн шинэчилсэн журмын талаар мэдлэг олгох сургалтад 40 албан хаагч хамрагдсан. Сумдын Засаг дарга нарт сумдынхаа байгаль хамгаалагч нарыг унаа /мотоцикл/-гаар хангаж асуудлыг шийдвэрлэж хамтран ажиллах талаар чиглэл хүргүүлж ажилласнаар 2023 онд Улаанхус сум ан амьтан ашигласны төлбөрийн орлогоос 2 байгаль хамгаалагч, Буянт сум 1 байгаль хамгаалагчийг мотоциклээр хангасан.	70
3	3	Байгаль орчны хамгаалах нөхөрлөлүүд, идэвхтэн байгаль хамгаалагчдад тодорхой дэмжлэг үзүүлэх чадавжуулах сургалт зохион байгуулах	3.0	Сургалт хийгдэж, нөхөрлөлүүдийн үйл ажиллагаа дэмжигдсэн байна	2022 онд 30 гаруй нөхөрлөлийн төлөвлөлийг хамааруулсан сургалт зохион байгуулсан	Байгаль орчны чиглэлийн 60 нөхөрлөлүүдийн төлөөлөл, 110 идэвхтэн байгаль хамгаалагч хамаарагдсан байна	Сумдын байгаль хамгаалагч, идэвхтэн байгаль хамгаалагч, нөхөрлөлүүдийн ахлагч нарыг хамруулсан нэгдсэн сургалтыг 4 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулж 15 нөхөрлөлийн төлөөлөл болон 40 гаруй идэвхтэн байгаль хамгаалагч хамрагдсан	100
4	4	БОАЖЯ.Герман улсын хамтын ажиллагааны KFW төслийн шугамаар хангагдсан ланд 79 авто машины гаалийн татвар төлөх	8.0	БОХамгаалах, хяналт шалгалт хийх үйл ажиллагаанд чиглэгдсэн байна.	2022 онд ланд 79 машинаар хангагдсан.	Хяналт шалгалтын ажил сайжирсан байна.	Байгууллагын ланд 79 автомашины гаалийн татварыг БОАЖЯ-ам, Герман улсын хамтын ажиллагааны KFW төслөөс төлөх болсон тул орон нутгийн төсвөөс шийдвэрлэсэн хөрөнгийг байгаль хамгаалагч нарыг улсын зөвлөгөөнд зориулан замын зардалд зарцуулав. Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Цагдаагийн газар, сумдын Засаг даргын Тамгын газартай хамтарч байгаль орчны хяналт шалгалтыг зохион байгуулан ажиллав..	100

5	5	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын албан хаагчдын нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх	10.0	Нийгмийн баталгаа сайжирсан байна.	2018 онд 3 ширхэг компьютер эр хангагдсан.	Мэргэжилтнүүдийг 5 ширхэг notebook- 3 ширхэг ширээний компьютер-ээр- 2 хангасан байна.	Улаанхус сумын Засаг даргын Тамгын газар нь ангийн орлогын давсан хэсгээс 2.2 сая төгрөг зарцуулан байгаль орчны хяналтын улсын байцаагчид нөөтбүүк, принтерээр хангасан. Мөн аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр Биологийн төрөл зүйл хариуцсан мэргэжилтэн, нягтлан бодогчийг тус бүр 1 суурин компьютерээр хангав. “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн II, III шатны санхүүжилтээр Байгаль орчин, аялал жуулчлалын газарт цахим хурлын тоног төхөөрөмж, ухаалаг дэлгэц, зөөврийн компьютер, дрон, зургийн аппарат, энгэрийн камер, хурд, зай хэмжигч, дуран, гар утас, телескоп нийлүүлж албан хаагчдыг 4 улирлын дүрэмт хувцсаар хангав.	100
6	6	Мэргэжилтэн байгаль хамгаалагч нарыг ОХУ болон БНХАУ-д туршлага солилцох ажлыг зохион байгуулах	10.0	Мэргэжилтэн байгаль хамгаалагч нарын мэдлэг, туршлага дээшилсэн байна	Өмнөх онд мэргэжилтэн, байгаль хамгаалагчид COVID-19 цар тархлын улмаас гадаад улсууд руу туршлага солилцох ажлыг зохион байгуулагдаагүй болно.	туршлага солилцох хүрээнд зохион байгуулагдсан ажлын тоо	2023 оны 4 дүгээр сард БНХАУ-ын ШУӨЗО-ы Алтайн аймагт Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга, аймгийн Аялал жуулчлалын холбооны тэргүүн болон аялал жуулчлалын салбарын төлөөллүүд ажиллаж хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар хэлэлцэж, зарим асуудлыг газар дээр нь шийдвэрлүүлэв. Мөн оны 6 дугаар сард “Шинэ сэргэлт”-ийн бодлогын хүрээнд Даянгийн боомтыг сэргээн ашиглалтад оруулахтай холбогдуулан тус аймгийн болон БНХАУ-ын ШУӨЗО-ны хооронд хил дамнасан аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор хоёр талын аялал жуулчлалын салбарын удирдлагууд, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын	100

						төлөөллүүдтэй цахим уулзалт зохион байгуулав.	
7	7	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын хэрэгжилтийг хангах, хуулийн хэрэгжилтийг 100 хувьд хүргэх;	Хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	2022 онд байгаль хамгаалах сангаас 367 сая төгрөгийг байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан.	Хууль, журмын хэрэгжилтийн хувь	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд аймгийн хэмжээнд нийт 642.8 сая төгрөгийг байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулав.	100
8	8	2024 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хувь хэмжээ, орлогоос зарцуулах арга хэмжээний төлөвлөлтийг Байгаль орчны төсөв зардлын мэдээллийн санд журамд заагдсан хугацаанд тогтмол оруулах ( <a href="http://www.eic.mn">www.eic.mn</a> );	Мэдээллийн санд хугацаанд оруулсан байна.	2023 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хувь хэмжээ, орлогоос зарцуулах арга хэмжээний төлөвлөлтийг Байгаль орчны төсөв зардлын	Мэдээллийн санг байжуулсан эсэх	Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-д заасны дагуу байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого, зарцуулалтын төлөвлөгөөг мэдээллийн сан( <a href="http://www.eic.mn">www.eic.mn</a> )-д заасан хугацаанаас өмнө оруулан ажиллав.	100

					мэдээллийн санд хугацаанд бүрэн оруулсан болно.			
Дундаж үнэлгээ								96.2
<b>2. Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийг хамгаалах</b>								
9	1	Зэрлэг амьтдад зориулж, биотехникийн арга хэмжээ авах	8.0	Аймгийн хэмжээнд өвөлжилт хүндэрсэн 6 ээс доошгүй сумдын нутаг дахь зэрлэг амьтдад биотехникийн арга хэмжээ авсан байна.	Ангийн 6 бүс нутагт био техникийн арга хэмжээ авсан.	Ангийн бүс нутагууд биотехникийн арга хэмжээ авсан эсэх	Баян-Өлгий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, менежмент хариуцагч Мармара Интернэйшнл ХХК-тай хамтран Цэнгэл сумын "Борбургас", Алтанцөгц сумын "Мундуйн дэвсэг", Буянт сумын "Эзэрлэг", Толбо сумын "Борт", "Зурхайчийн нуруу", Дэлүүн сумын "Улаан говь". Улаанхус сумын "Мянган уул", Монгол сафари ХХК-тай Улаанхус сумын "Агуйт хатуу", Бугат сумын "Төмөрт" агнуурын бүс нутагт, "Вестерн хантинг монголиа" ХХК-тай хамтран, Буянт сумын "Тошинт-Харгайт" агнуурын бүс нутагт Сагсай сумын "Бөхөн" агнуурын бүс нутагт "Мэргэд" ХХК-тай, Ногооннуур сумын "Бахлаг" агнуурын бүс нутагт "Маунтэйнг Хантинг" ХХК-тай Алтай сумын "Цалгарын цагаан булаг АБГ, Цэнгэл сумын "Баян Цэнгэл" агнуурын бүс нутагт "Хано Маро Тур" ХХК-тай Дэлүүн сумын "Ахуунт" агнуурын бүс нутагт Монголиан Адвентертурс ХХК-тай хамтран нийт 30.0 гаруй сая төгрөгний санхүүжилтээр зэрлэг	100

						ан амьтад зориулан өвс, хужир давс тавьж биотехникийн арга хэмжээг зохион байгуулан ажиллаа. Амьтны нөөц ашигласаны төлбөрөөс Ногооннуур сум 28,0 сая төгрөг, Буянт сум 5.8 сая төгрөгөөр ан амьтад биотехникийн арга хэмжээ авч ажилласан.	
10	2	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, дахин ашиглах, дахин боловсруулах 3R цогц менежментийг хэрэгжүүлж эдийн засгийн эргэлтэд оруулах	Аймгийн хэмжээгээр бууруулах, дахин ашиглах, дахин боловсруулах 3R менежментийг хэрэгжүүлж эдийн Засгийн эргэлтэнд оруулсан байна.	Аймгийн хэмжээнд Өлгий суманд 2022 онд дахин боловсруулах хог хаягдлыг суглуулж преслэн хотод ачуулсан.	Дахин боловсруулах хог хаягдлыг эргэлтэнд оруулсан эсэх	Аймгийн төвийн аж ахуйн нэгж байгууллагуудын дунд хог хаягдлын тухай хуулийг сурталчлах, байгаль орчноо цэвэрлэх, дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг эргүүлэн ашиглах, дахин боловсруулах, ангилан ялгах хогийн савтай болгох, ангилан ялгаж хэвшүүлэх зорилгоор "ХОЛИВОЛ ХОГ, АНГИЛБАЛ БАЯЛАГ" уралдаан зохион байгуулж, цуглуулсан дахиврийг Хот тохижуулах албанд хүлээлгэн өгч хотруу ачуулав. Мөн 400 варений шилийг "Алтайн тараг" ХХКомпанид, 1 портер хуванцарыг "Казос" ХХКомпанид өгч, хуучин хувцасыг хэрэгтэй хүнд тарааж өгөв. Түүнчлэн уралдаанд идэвхтэй оролцсон 8 аж ахуйн нэгж, байгууллагуудыг өргөмжлөл мөнгөн шагналаар шагнав. 2. Мөн аймгийн төвийн төв талбайд орон нутгийг жөгжүүлэх сангийн хөрөнгөөр 2 том оврын ангилан ялгах хогийн	100



						сав хийлгэж байршуулсан. 2023 онд нийтдээ 12 аж ахуйн нэгж байгууллагууд ангилан ялгах хогийн савтай болсон. Алтай сумын Улаанхад багийн бага сургууль нь төрийн бус бейгууллагын хөрөнгө оруулалтаар хогны цэгтэй, хог зөөх машинтай, сургууль, дотуур байр, биеийн тамирын талбай, тоглоомын талбайн гадаа хогоо төрөлжүүлэн хийх хогны савнуудтай боллоо. "Казос" ХХК өөрийн хөрөнгөөр хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр байгуулахаар төлөвлөн дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг цуглуулж байна. Орчны бохирдлыг буруулах үндэсний хорооноос зохион байгуулсан "Гэрэлт ирээдүйн төлөө аюулыг авдарлая-2" уралдаанд аймгийн хэмжээний ЕБ-ын 23 сургуулийн сурагчид орлцож хэрэглэхгүй байгаа гар утас, батерей, цэнэглэгч, хуруу зай, эм бэлдмэл зэрэг нийт 3.6 тонн аюултай хог хаягдал, 297.6 кг эвдэрсэн гар утасны хаягдлыг цуглуулж, Улаанбаатар хотруу ачуулав.		
11	3	Хууль бус ашигт малтмал олборлолтыг таслан зогсоох хяналт шалгалтыг эрчимжүүлэх	Орон нутгийн төсөв	2-оос доошгүй удаа хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан байна.	2022 онд 3 удаа хяналт шалгалтын ажил зохион байгуулсан	Хяналт шалгалтын тоо.	Өлгий, Бугат сумдын нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмал олборлож болзошгүй газруудад 2023 оны 04 дүгээр сард Байгаль орчны хяналтын улсын / ахлах / байцаагчид, Цагдаагийн газрын холбогдох албан хааг нартай хамтарч хяналт шалгалт хийх явцад Бугат сумын нутаг дэвсгэрт орших Ховд голын эргээс хууль бусаар хайрга олборлож тээвэрлэсэн 2 тээврийн хэрэгслийг илрүүлж, холбогдох байгууллагад үргэлжлүүлэн шалгуулахаар харьяаллын дагуу шилжүүлэн ажиллав.	100

12	4	“Нөхөн сэргээлт-2024” нэгдсэн арга хэмжээний аймгийн дэд ажлын хэсгийн үйл ажиллагааг эрчимжүүлж, дэмжиж ажиллах	Орон нутгийн төсөв	Ажлын хэсгийн үйл ажиллагааг эрчимжүүлсэн байна.	Дэд ажлын хэсгийн төлөвлөгөө ний биелэлт гаргасан	Ажлын хэсгийг үйл ажиллагааг хэвийн явуулах санхүүжилтийг шийдвэрлэсэн байна.	Толбо суманд баригдсан 2.3 км хатуу хучилттай авто замд ашигласан 2 га хайрагны талбай болон Бугат сумын Хатуу багийн нутагт баригдсан бетон гүүрэнд ашигласан 2 га, Алтай сумын төвд хатуу хучилттай авто замд ашигласан 1.7га хайрагны карьерийн талбайг нөхөн сэргээж орон нутагт актаар хүлээлгэж өгөв.	100
13	5	Хууль бус анг таслан зогсоох талаар холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах	Орон нутгийн төсөв	Хууль бус ангийн гэмт хэрэг багассан байна.	-		Хууль бусаар 1 тооны зэгсний гахай агнасан зөрчлийг илрүүлж, зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж харьяаллын дагуу шалган шийдвэрлүүлэхээр Цагдаагийн газарт хүргүүлж ажиллав. 2023 оны 08 дугаар сард Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, ЗӨСТ, Өлгий сумын ЗДТГазартай хамтарч нийт 45 хоног эргүүлийн хяналт шалгалт хийж ажиллан, хяналт шалгалтын явцад хууль бусаар 97 ширхэг алтай тарвага агнасан зөрчлийг илрүүлж 74 ширхэг алтайн тарвага агнасан 13 иргэнд 3,900,000 төгрөгийн торгуулийн шийтгэл, 68,080,000 төгрөгийн нөхөн төлбөр ногдуулж, хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж ажилласан ба зөрчил үйлдэхэд ашигласан 13 ширхэг галт зэвсгийг хураан авч, аймгийн Цагдаагийн газарт хүргүүлэн ажилласан байна. Мөн 23 ширхэг алтайн тарвага агнасан 2 зөрчилд зөрчлийн хэрэг нээж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж байна. Нийт шалгалтаар илрүүлсэн 97 ширхэг алтайн тарвагыг шинжлүүлэхээр аймгийн Зооноз өвчин судлалын төвд хүлээлгэн өгч ажиллав.	70
Дундаж үнэлгээ								94
<b>3.Усны нөөцийн ашиглах, хамгаалах</b>								

14	1	Булаг шандын эхийг хамгаалж, орчныг тохижуулах	12.0	Усны нөөцийг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээгдэх боломж. бүрдүүлж булаг шандны эхийг хашиж орчныг тохижуулсан байна.	2022 онд Баяннуур, Ногооннуур, Алтанцөгц сумуудын 3 булгийн эхийг хамгаалсан байна.	3-с доошгүй булаг шандны эхийг хамгаалж, орчныг тохижуулсан байна.	Улаанхус сумын ПУРГОН клубын залуучууд тус сумын Билүүгийн рашааны эргэн тойроны хог хаягдлыг цэвэрлэж, өмнөх бие засах газрыг засварлаж, машины зогсоолтой, хог хаях савтай болгосон байна. Хөдөлмөр, халамж үйлчилгээний газартай хамтран 10 хүнийг 10 өдөр түр ажлын байраар хангаж, Буянт сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт 1 булгийн эхийг хамгаалсан хашааг засварлах, тохижуулах ажил хийсэн. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос Алтай, Бугат сумдад тус бүр 1 булаг шандын эхийг тохижуулах ажлыг хийсэн.	100
15	2	Усны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4-т заасны дагуу усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс, ус хангамжийн эх үүсвэрийн тэжээгдлийн мужийн заагийг ИТХ-аар тогтоож, Хууль зүйн яаманд бүртгүүлж, дэглэмийг мөрдүүлж, тэмдэгжүүлэх		Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийг тогтоож ИТХ-аар батлуулж дэглэмийг мөрдүүлсэн байна.	Өлгий хотын усан хангамжийн бүсийг эрүүл ахуйн бүсэд хамааруусан.	Хамгаалалтын бүсийг тогтоож ИТХ-аар батлуулсан, батлагдсан захиргааны хэм, хэмжээний актыг бүртгүүлэх	Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/276 дугаартай захирамжаар аймгийн нутаг дэвсгэр дэх дэвсгэр дэх усан сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн хориглолтын ба хязгаарлалтын бүс, ус хангамжийн тэжээгдлийн мужийн заагийг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран тогтоох ажлын хэсэг байгуулсан. Түүнчлэн дэлхийн байгаль хамгаалах сангийн аймаг дахь төлөөлөгч, бусад холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран 12 суманд хүрч, уулзалт, сургалт сурталчилгааны ажлуудыг хийж 2000 ширхэг гарын авлага тарааж ажиллав. Сагсай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас хамгаалалтын бүс тогтоох шийдвэр гарсан.	70
16	3	Усны нөөцийг бохирдож, хомстохоос хамгаалах зорилгоор худгийн тооллого хийж, хяналтыг хэрэгжүүлэх		Гүн өрмийн худгийн тооллого үнэн бодит хийгдсэн.	2022 онд аймгийн хэмжээн дэх худгийн тооллого хийгдсэн	Худгийн тооллого хийгдэж, хяналт сайжирсан байна.	Байгаль орчин, аялал жуулчлалын газраас сумдын Засаг даргын Тамгын газартай хамтран аймгийн хэмжээний худгийн тооллого хийх ажлыг зохион байгуулсан ба аймгийн хэмжээнд нийт 604 гүн өрмийн худаг тоологдсон.	100

				болно.			
17	4	Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс, тэжээгдлийн мужид байгаа зуслан, суурьшлын бүсийн байгаа айл өрхөд хөрс, усанд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх технологи, гарц шийдлүүдийг тодорхойлж, сурталчилан таниулж, хэрэгжүүлэх	Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс, тэжээгдлийн мужид байгаа зуслан, суурьшлын бүсийн хөрс, усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл зохих түвшинд багсана.	Гол мөрний сав газруудын дагуух хөрсний бохирдол үүсгэгч нүхэн жорлонгийн хэрэглээг зогсоож, усны нөөцийг бохирдож, хомстохоос хамгаалах чиглэлээр гаргасан Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны 09 дүгээр сарын 19 –ний өдрийн 11 дүгээр албан албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах ажлуудыг зохион байгуулав	Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс, тэжээгдлийн мужид байгаа зуслан, суурьшлын бүсийн байгаа айл өрхөд Ард иргэдэд тогтмол сурталчилгаа явуулах	Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/276 дугаартай захирамжаар аймгийн нутаг дэвсгэр дэх дэвсгэр дэх усан сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн хориглолтын ба хязгаарлалтын бүс, ус хангамжийн тэжээгдлийн мужийн заагийг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран тогтоох ажлын хэсэг байгуулсан. Түүнчлэн дэлхийн байгаль хамгаалах сангийн аймаг дахь төлөөлөгч, бусад холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран 12 суманд хүрч, уулзалт, сургалт сурталчилгааны ажлуудыг хийсэн.	100

18	5	Ус бохирдуулагчийн эх үүсвэрийн тооллого хийх		Улсын усны мэдээлийн санд бүртгэгдсэн байх	2022 онд аймгийн хэмжээнд 481 ус бохирдуул агч аж ахуйн нэгж байгууллага тоологдож мэдээлэлийн санд бүрэн оруулсан.	Ус бохирдуулагчийн эх үүсвэрийн тооллого хийгдсэн байна.	2023 онд Байгаль орчин, аялал жуулчлалын газраас сумдын Засаг даргын Тамгын газартай хамтран аймгийн хэмжээний аймгийн хэмжээний Ус бохирдуулагчийн эх үүсвэрийн тооллого хийсэн ба нийт 490 ус бохирдуулагч тоологдсон.	100
Дундаж үнэлгээ								94
<b>4.Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах</b>								
19	1	Байгалийн нөөцийг хамгаалах ажлын хүрээнд Чигэртэйн голын ай савын БЦГ-ын тодорхой цэгүүдэд ан амьтны тооллогыг 2 удаа зохион байгуулж (төллөх үе, орооны үе) Биотехникийн арга хэмжээг үр дүнтэй авч хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах.	2.0	5 цэгт 1 удаа биотехникийн арга хэмжээ авсан байна.	Жилд -5 цэгт 1 удаа биотехникийн арга Хэмжээг зохион зохион байгуулсан байна.	Чигэртэйн голын ай савын БЦГазар	Монгол Алтайн нурууны Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны даргын 2023 оны 03 дугаар сард баталсан удирдамжийн дагуу Монгол Алтайн нурууны УТХГазруудын хамгалалтын захиргааны Алтай Таванбогдын БЦГазрын Шивээт хайрхан, Талдгийн их уул, Их Ойгорын эх, Сонгинот, Сийлхэмийн нурууны БЦГ-ын "А", "Б" хэсэг түүний орчны бүс болох Хүрэн хайрхан уул орчмын уулын туурайтан амьтан болох аргаль хонь, янгир ямаа, халиун буга зэрэг ан амьтдад давхардсан тоогоор 13 цэгт 9 тонн давс тавьж, биотехникийн арга хэмжээ авч, өвөлжилтийн байдалд ажиглалт, мониторинг хийж ажиллав. Цаг агаар хүндэрсэн үед ан амьтдад тавих зориулалтаар Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 200 ширхэг боодол өвс авч, нэмэлтээр биотехникийн арга хэмжээ авч ажилласан. Хөх Сэрхийн нурууны Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны даргын баталсан	100

						удирдамжийн дагуу ан амьтанд зориулан биотехникийн арга хэмжээг нийт 4 цэгт 10 удаа авч хэрэгжүүлэв. Чигэртэйн голын ай савын БЦГ-ын Улаан хөндий, Тошины нуруу, Үерт, Нүцгэн чиглэлд аргаль хонины төллөх үеийн тооллого судалгааг 4, 5 дугаар сард 3 удаа хийж гүйцэтгэв. Хургалах үеийн тооллого судалгаагаар нас бие гүйцсэн аргаль (давхцсан тоогоор) 68, төлөг 28, хурга 41, нийт 137 аргаль хонь бүртгэв. Мөн халиун бугын тооллого судалгааг тусгай хамгаалалттай газар нутагт хийж нийт 58 тооны халиун буга бүртгэж мэдээллийн санд оруулсан.	
20	2	Улсын тусгай хамгаалалттай газар нутагт зөрчлөөс урьдчилан сэргийлэх хамтарсан хяналт шалгалт хийх	Хамтарсан хяналт шалгалтыг 4-өөс доошгүй удаа зохион байгуулсан байна.	Хамгаалалтын захиргаа, Цагдаагийн газар, сумын ЗДТГ-тай тогтоомол зохион байгуулдаг	УТХГН-т хамаарагдах сумдад	2023 онд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Байгаль орчны хяналтын улсын байцаагчийн бөгөөд хуулийн хэрэгжилт, хяналт шалгалт хариуцсан ахлах мэргэжилтэн, байгаль хамгаалагч нартай хамтран давхардсан тоогоор төлөвлөгөөт хяналт шалгалтыг 54 удаа, төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 82, гүйцэтгэлийн шалгалтыг 54, урьдчилсан хяналт шалгалтыг 48 удаа, хамтарсан хяналт шалгалтыг 2 удаа, нийт давхардсан тоогоор 240 удаа хяналт шалгалтын ажлыг тус тус хийж гүйцэтгэв. Хяналт шалгалтын ажлын үед 20 хүнд сануулга өгч, Даян багт оршин суудаг 30 айл өрхөд стандарт шаардлага хангаагүй нүхэн жорлонг буулгах талаар амаар шаардлага тавьж, биелэлтийг хангуулж ажиллав. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын “Эрүүл аюулгүй-Цэвэр орчин” бүрдүүлэх арга хэмжээний тухай 2023 оны 04 дүгээр албан даалгаврын хүрэнд байгаль хамгаалагч бүр өөрсдийн хариуцан хамгаалдаг газар нутагт болон зам дагуух хуурай хог хаягдал, малын сэг зэмийг цэвэрлэж, нийт 15 тн хог хаягдлыг ачиж хогийн нэгдсэн цэгт тээвэрлэн хүргэж,	100

							ариутгах, халдваргүйжүүлэлтийг багийн малын эмч нартай хамтран зохион байгуулсан.	
21	3	Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаатай хамтран тусгай хамгаалалттай газрын орчны бүсэд амьдарч буй иргэдэд Байгаль орчныг хамгаалах чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах		Тусгай хамгаалалттай газар нутагт сургалт сурталчилгааг 4-өөс доошгүй удаа зохион байгуулсан байна.		УТХГН-т хамаарагдах сумдад	Алтай Таванбогдын БЦГ-ын орчны бүсийн Алтай, Сагсай, Цэнгэл, Сийлхэмийн нурууны байгалийн цогцолборт газрын орчны бүсийн Улаанхус, Ногооннуур сумдын нийт 5 “Орчны бүсийн зөвлөл”-ийг чадавхжуулах сургалтыг байгаль хамгаалагч нартай хамтран зохион байгуулав.	100
22	4	Улсын тусгай хамгаалалттай газар нутагт амьдардаг малчин иргэдтэй газар ашиглах гурвалсан гэрээ байгуулах		Тусгай хамгаалалттай газар нутаг бүхий сумдын малчин иргэдийн гурвалсан гэрээг шинэчлэн байгуулсан байна.	Газар ашиглах гурвалсан гэрээ байгуулсан ... Иргэн байдаг.	Улсын тусгай хамгаалалттай сумдын малчин иргэд	Авлигатай тэмцэх газар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын илрүүлсэн албан бичгийн дагуу гурвалсан гэрээг түр зогсоосон	Үнэ лэх бол омжгүй
23	5	ЗГ-ын 2018 оны №384 дугаар тогтоолоор баталсан Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөөнд туссан улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх газруудыг үе шаттайгаар хамгаалалтад авах ажлыг зохион байгуулж тогтоолын хэрэгжилтийг хангах		Улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд туссан экологийн хувьд чухал хамгаалах шаардлагатай газар нутгуудыг аймаг нийслэлийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж хил зааг,	Аймгийн нийт газар нутгийн 28.5%-ийг улсын тусгай хамгаалалтад авсан.	Улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан байршлууд: Тал нуур-Далайн хөх уул-Хөш уул-Хөх сайн уул орчмын газар нутаг, Цэнгэл хайрхан-Цагаан асга, Чигэртэйн голын ай савын өргөтгөл Сагсай ай сав, Ачит нуур-Дэвэлийн арлын өргөтгөл, Ховд голын	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хийлгэж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулсан аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд “Улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд туссан экологийн хувьд чухал	50

				байршил хэмжээг мэдээллийн санд бүртгэж, ИТХ-аар хэлэлцүүлж баталсан байна.		цутгал, Толбонуур-Хүнгүй нуруу, Олон нуур, Сийлхэмийн нуруу Б өгөтгөл, Сийлхэмийн нуруу өргөтгөл А, Булган голын эх-Хар нуур	хамгаалах шаардлагатай газар нутгууд"-ыг тусгаж хил зааг байршил хэмжээг мэдээллийн санд бүртгэсэн.	
24	6	Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах саналыг Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлэх		Улсын тусгай хамгаалалтад авах газруудын жагсаалтыг гаргаж, зохих шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлсэн байна.	Байгаль орчин, аялал жуулчлалын яамны захиалгаар Байгаль орчны судалгаа хөгжлийн төв ТББ-аас 2021 онд үндэслэлийн судалгааг хийж гүйцэтгэсэн. Аймгийн нийт газар нутгийн 28.5%-ийг улсын тусгай хамгаалалтад авсан.	Улаанхус сумын нутагт орших Олон нуурт орчмын газар нутгийг байгалийн нөөц газрын ангиллаар, Сийлхэмийн нурууны байгалийн цогцолборт газрын "А" хэсгийг Бага Ойгор, Цагаан салаа зэрэг хадны сүг зургийн цогцолборыг оролцуулан өргөтгөхөөр, Буянт сумын нутаг дахь Зоо-Бөөрөгт-Эзэрлэгийн нуруу орчмын газар нутгийг байгалийн нөөц газрын ангиллаар, Дэлүүн сумын нутагт орших Чигэртэй голын ай сав орчмын газар нутгийг байгалийн цогцолборт газрын өргөтгөлөөр тус тус улсын тусгай хамгаалалтад авах	Улсын тусгай хамгаалалтад авах газруудын жагсаалтыг гаргаж, сумын санал авч, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 04 дүгээр сарын 05 өдрийн ээлжит хуралдаанаар хэлэлцүүлсэн боловч дэжигдээгүй тул "Зарим газрыг улсын тусгай хамгаалалтад авахаас татгалзах тухай" 62 дугаартай тогтоол гаргаж ирүүлсэн болно.	50
Дундаж үнэлгээ								80
<b>5. Ойн нөөцийг хамгаалах, "Тэрбум мод" хөдөлгөөнийг өрнүүлж, зорилтын хэрэгжилтийг хангах</b>								
25	1	Тэрбум мод үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээнд	300.0	Ойн нөхөн сэргээлтийн ажил нэмэгдсэн байна	2022 онд 172964 мод таригдсан.	Бүх сумдад	Мод үржүүлгийн талбайн тарьц суулгацын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор 2023 онд 70,000 ширхэг улиас, бургас модны мөчир, 100,000 гаруй хайлаас зэрэг моднуудын тарьц суулгац тарьж 90 хувийн амьдралтай ургуулан ажиллаж байна. Одоогийн байдлаар мод үржүүлгийн талбайд 530,000 гаруй улиас, бургас, хайлаас модны	100



						<p>суулгацын нөөцтэй үйл ажиллагаа явуулж байна. Мөн Бугат, Толбо сумын нутаг дэвсгэрт 2 аж ахуйн нэгж мод үржүүлгийн үйл ажиллагаа явуулж байна. 2023 онд нийт 60.0 мянга гаруй мод тарьж арчлан 80 хувийн амьдралттай ургуулж байгаа ба ногоон байгууламжийн хэмжээг 10 га-р нэмэгдүүлсэн үзүүлэлттэй байна. Мөн ба намар мод тарих арга хэмжээнд 34.7 сая төгрөгөөр 10 мянга ширхэг гоёлын модны тарьц суулгац худалдан авч, 2024 оны хаврын тарилтаар тарихаар зориулалтын зооринд хадгалав. Цөлжилтийг сааруулах, хөрс хамгаалах зорилгоор Буянт суманд 2 иргэн 0.5 га, Алтанцөгц суманд "Бекжанай" ХХК 5 га, нийт 6 га талбайд чацаргана тариалсан. Хөх Сэрхийн нурууны УТХГ-ын хамгаалалтын захиргаанаас "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд орчны бүсийн Дэлүүн сумын мод үржүүлгийн талбайд 100 ш бургас, хамгаалалтын захиргааны мод үржүүлгийн газарт 500 ш чацаргана, 400 ш бургас нийт 1000 ш мод суулгаж арчилгаа, усалгааны ажлыг хийж байна. Субэндемик ургамлыг байгалийн аясаар нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх, мөн тарималжуулах замаар түүний генетик нөөцийг хамгаалах, цаашид энэ ажлын үр дүнг иргэд, олон нийтэд болон эко кулбүүдээр дамжуулан бүс нутгийн сурагчид, залуу үеийнхэнд ойлгуулах, экологийн боловсролыг нэмэгдүүлж мэдлэг, хандлагыг өөрчлөхөд ажлын гол зорилгоор Алтай Таванбогдын БЦГ-ын Даянгийн хөндийд 1,5 га газарт шинээр төмөр тороор хашаа татаж 2 настай шинэс 300 ширхэг, Далиу сонгино (Сармисан сонгино) (<i>Allium obliquum</i>L)-ын суулгац 10 ширхэг тус тус суулгав. Монгол Алтайн нурууны улсын тусгай хамгаалалтай газрын хамгаалалтын захиргаанаас Цэнгэл</p>	
--	--	--	--	--	--	---	--

							сумын Шар Говийн эх дэх Хар Татарын 126 га ойжуулсан талбайд 2 га газарт 900 мөчирөөр тарих ажлыг хамгаалалтын захиргааны мэргэжилтэн, байгаль хамгаалагч нар зохион байгуулж ажиллав.	
26	2	Мод үржүүлэг, ойжуулалт, ойн зурвас, суурин газрын цэцэрлэгжүүлэлтийн зориулалтаар ажил хийх хүсэлт ирүүлсэн аж ахуйн нэгж, иргэдэд шаардлагатай газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авч, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган, холбогдох хууль, журмын дагуу шуурхай шийдвэрлэж ажиллах		Мод үржүүлэг, ойжуулалт, ойн зурвас байгуулах хүсэлт ирүүлсэн Иргэн ААНэгж, байгууллагын хүлээн авч, мэргэжлийн арга зүйн зөвлөгөө өгч, дэмжиж ажиллана.	2022 онд Мод үржүүлэг, ойжуулалт, ойн зурвас, суурин газрын цэцэрлэгжүүлэлтийн зориулалтаар ажил хийх хүсэлт ирүүлсэн 3 иргэн, ААНэгж байгууллага хүсэлтийг хүлээн авч, зохих хууль, журмын дагуу шийдэж өгөх талаар холбогдох газарт уламжлан ажиллав, .	Аймгийн хэмжээнд	Аймгийн төв буюу Өлгий сумын хэмжээнд 114 га газрыг Мод үржүүлэг, ойжуулалт, ойн зурвас, суурин газрын цэцэрлэгжүүлэлтийн зориулалтаар ашиглуулахаар аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгасан, 2022-2023 онд 40 орчим га-д нь мод тарьж ургуулах ажил хийсэн. Мод үржүүлэг, ойжуулалт, ойн зурвас, суурин газрын цэцэрлэгжүүлэлтийн зориулалтаар ажил хийх хүсэлт ирүүлсэн аж ахуйн нэгж, иргэдэд шаардлагатай газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авч, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган хамтарч ажиллах талаар сумдын Засаг даргын газарт чиглэл хүргүүлэн ажиллав.	90
Дундаж үнэлгээ								95
<b>6. Аялал жуулчлалыг хөгжүүлэх</b>								
27	1	"Ай Ти Эм" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд аялал жуулчлалын компаниуд болон иргэдийг оролцуулах	5.0	12-аас дээш аж ахуйн нэгж хамрагдсан байна.	2022 онд 10 ААНБ оролцсон	12-15 аж ахуйн байгуулагыг оролцуулсан байна.	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 1.8 сая шийдвэрлэн өгч, Улаанбаатар хотод 2023 оны 10-р сарын 27-29 ний өдрүүдэд зохион байгуулагдсан "Ай Ти Эм-2023" олон улсын үзэсгэлэнд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, аялал жуулчлалын холбоо болон "Гранд Алтай травел" ХХК, "Баавгайн хөндий" ХХК зэрэг 14 аж ахуйн нэгжийн төлөөллүүдийг оролцуулан сурталчилгааны ажлыг зохион байгуулсан.	100
28	2	Аялал жуулчлалын форум зохион байгуулах	8.0	42 аж ахуйн нэгж хамрагдсан байна		85 аж ахуйн нэгж байгууллага оролцуулсан байна	2023 оны 11 дүгээр сарын 23, 24-ний өдрүүдэд хийсэн "Нээлттэй Баян-Өлгий" эдийн засгийн чуулга уулзалтын нэг салбар хуралдаанаар аймгийн аялал жуулчлалын талаар нээлттэй хэлэлцүүлэг зохион	90

							байгуулж, нийт яам Тамгын газар болон аялал жуулчлалын салбарын 30 гаруй аж ахуйн нэгжийн нийт 150 гаруй хүн оролцов. Мөн чуулга уулзалтын үеэр Хөгжимт драмын театрын танхимд "Баян-Өлгий аймгийг Аялал жуулчлалын 4 дүгээр бүс" уриан доор Байгаль орчин, аялал жуулчлалын газрын хамт олон болон Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Altai expedition, Explore the great Altai, Nomads dream travel, Discover altai travel, Lena tour agency, Eagle Hunter camp, Altai trekking travel, Орман ан ХХК, Traveler,s guest house, Grand Altai travel, Kazakh nomads travel, Altai lodge camp, Golden eagle tour, Sunny sky travel зэрэг аж ахуйн нэгж, байгууллагууд үйл ажиллагаагаа болон аяллын маршрут болон хөтөлбөрүүдээ танилцуулан аялал жуулчлалын үзэсгэлэн зохион байгуулав.	
29	3	Бүргэдийн баяр эвэнт арга хэмжээ зохион байгуулах	Хувийн хэвшил /Монголын бүргэдчдийн холбоо/	Гадаад, дотодын жуулчдын тоо нэмэгдсэн байна.	2022 онд гадаад дотоодын 5000 гаруй жуулчин оролцсон.	Бугат сум /Өнчин толгой/	Дэлхийн өвд бүртгэлтэй Казах ард түмний өвөрмөц ёс заншил ,бүргэдээр ан хийх соёлын өвийг дэлхийд сурталчлан таниулсан аялал жуулчлалын хамгийн том арга хэмжээ болох "Бүргэдийн баяр-2023" эвэнт арга хэмжээ 24 дахь удаагаа 2023 оны 9 дүгээр сарын 30, 10 дугаар сарын 01-ний өдрүүдэд Буянт сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт "Хойлог толгой хэмээх газарт "Казак шувуулахуйн холбоо" амжилттай зохион байгууллаа. Уг эвэнт арга хэмжээнд гадаадын 800 гаруй жуулчин оролцон аялал жуулчлалын салбарт 72.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалт орлоо.	100
30	4	Бүргэдийн баяр эвэнт арга	8.0	Гадаад, дотодын жуулчдын тоо нэмэгдсэн байна.	-	Улаанбаатар хотод	"Чингис хааны хүрээ" аялал жуулчлалын цогцолборт 2023 оны 03 дугаар сарын 04, 05- ны өдрүүдэд зохион байгуулсан үндэстнийхээ ёс зан заншил, өв уламжлал, дахин давтагдашгүй өвөрмөц соёлыг сурталчлан таниулахын зэрэгцээ залуу	100

						үедээ өвлүүлэн үлдээх, гадаад, дотоодын жуулчдыг татах, нийслэлийн иргэдийн амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилго бүхий "Бүргэдийн Баяр-2023" эвент арга хэмжээнд, тус аймгаас 11 бүргэдчдийг оролцуулан хамтарч ажиллав.	
Дундаж үнэлгээ							
<b>ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ 92.7 %</b>							
							98

Баян-Өлгий аймгийн Засаг даргаас Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдтай байгуулсан гэрээнд нийт 30 арга хэмжээ тусгагдснаас 100 хувьтай 22 арга хэмжээ, 90 хувьтай 2 арга хэмжээ, 70 хувьтай 3 арга хэмжээ, 50 хувьтай 2 арга хэмжээ, үнэлэх боломжгүй 1 арга хэмжээ байгаа ба ерөнхий дүнгээр 92.7 хувийн хэрэгжилттэй үнэлэгдлээ.

**БИЕЛЭЛТ ГАРГАСАН:**

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Т.АРИУНЦЭЦЭГ

**ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Х.БАХЫТГҮЛ

**ҮНЭЛГЭЭ ХЯНАСАН:**

ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА

Х.ВИТА

**ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:**

ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

К.ЗАНГАР

**ТАНИЛЦСАН:**

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Б.МУХАМЕД

